



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР**



Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ

2024 оны 9 дүгээр сарын байдлаар

Мөрөн сум


1. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

1.1. Төрөлт

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 1448 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 227 тохиолдол буюу 13,6%-иар буурсан байна. Төрөлт Бүрэнтогтох, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Цагаан-Уул, Цэцэрлэг, Цагааннуур сумдад өсч, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Төрсөн эхчүүдийн 1066 нь буюу 73,6 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. Нийт төрөлтийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байгаа бөгөөд Бүрэнтогтох, Цэцэрлэг, Мөрөн суманд бүртгэгдсэн байна.

2024 оны эхний 9 сарын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд 24.9 хувийг эзэлж, нийт төрөлтөөс 25,5 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 74,5 хувь нь хүндрэлгүй төрсөн байна. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 10.5 байна.



1.2 Хүүхдийн эрүүл мэнд

2024 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд 1450 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 232 хүүхдээр буюу 16,0 хувиар буурчээ.

Амьд төрсөн хүүхдийн 738 буюу 50.9 хувь нь хүү, 712 буюу 49.1 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 104 хүү ногдож байна.

Амьд төрсөн нийт хүүхдээс 58 нярай буюу 4.0 хувь нь 2500 грамаас доош жинтэй, 13 тохиолдол буюу 0.9 хувь нь төрөлхийн гажигтай төрсөн байна. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 97.7 байна. Дутуу төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 59.3 байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 6.2 байна.

2024 оны эхний 9 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад 42091 хүүхэд хамрагдсанаас 0.02 хувь нь туранхай, 0.1 хувь нь тураалтай, 0.1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 58,2 хувь нь Д амин дэм, 7.5 хувь нь олон найрлагат бичил тэжээл, А амин дэмийг 10273 хүүхэд хэрэглэсэн байна.

1.3. Эхийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Сүүлийн 5 жилийн дундажаар 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 45,0 байна.

1.4. Нялхсын эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 23 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 15,9 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 65,2 хувь нь эрэгтэй, 34,8 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийн 65,2 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 10,3 байна. Нярайн эндэгдлийн нийт 15 тохиолдлын 9 буюу 60,0 хувь нь эрт үеийн эндэгдэл, 6 буюу 40,0 хувийг хожуу үеийн эндэгдэл тус тус эзэлж байна.

2024 оны эхний 9 сарын байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг сумуудаар харьцуулбал: Арбулаг (333,3), Бүрэнтогтох (250,0), Галт (333,3), Ханх (125,0) сумууд аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна.


Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үеийн эмгэг 43.5 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 21.7 хувь, гадны шалтгаант осол гэмтэл 17,4 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 17.4 хувийг тус тус эзэлж байна.





1.5. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2024 оны эхний 9 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 6 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 5 тохиолдлоор буурсан, 1000 амьд төрөлтөнд 4,1 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл амьсгалын тогтолцооны эмгэг 3, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 3 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.



1.6. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 29 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 20,0 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор өссөн байна.

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 19 тохиолдол буюу 65,5 хувь нь эрэгтэй, 10 тохиолдол буюу 34,5 хувь нь эмэгтэй хүүхэд байна.



Нийт тохиолдлын 31,0 хувь нь гэртээ болон гудамж талбайд, 69,0 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт 26,1 хувийг эзэлж байна. Шалтгаанаар авч үзвэл: Нийт эндэгдлийн 75.9 хувь нь өвчнөөр, 24.1 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна. Перинаталь үед үүссэн эмгэг 34.5 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 17.3 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 24.1 хувь, гадны шалтгаант осол гэмтэл 24,1 хувийг тус тус эзэлж байна.

Сумуудаар харьцуулбал: 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Арбулаг (333,3), Бүрэнтогтох (500,0), Галт (333,3), Жаргалант (333.3), Тариалан (66.7), Ханх (125,0), Хатгал (62.5) сумууд аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна.



2. ХҮН АМЫН НАС БАРАЛТ


2024 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд нас баралтын 573 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 37 тохиолдлоор өссөн байна.

Нийт нас баралтын 368 тохиолдол буюу 64,2 хувь нь эрэгтэй, 205 буюу 35,8 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 18,2 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 39 тохиолдол буюу 37,5 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор буурсан байна.

Нас баралтын түвшин 1000 хүн амд 4,2 байна. Нас баралтын 4,0 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5.1 хувийг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна.

Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 16.4
2. Хавдар-12.2
3. Гадны шалтгаант өвчлөл- 7.1
4. Амьсгалын тогтолцооны өвчин-1.8
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-1.1



Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 97 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 16,9 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 29 тохиолдлоор өссөн бөгөөд 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 7.1 байна.




4. ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ

2024 оны эхний 9 сарын байдлаар аймгийн нэгдсэн эмнэлэгт нас баралтын 71 тохиолдол бүртгэгдсэнээс 46,5 хувьд нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийгдсэн байна. Аймгийн хэмжээнд үндсэн оношийн зөрүү 5 тохиолдол бүртгэгдсэн байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 38 тохиолдол байна.

5. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

5.1 Амбулаторийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар нийт 533213 эмчийн үзлэг хийгдсэнээс 44.8 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 39.4 хувийг өвчний учир амбулаторт, 6.0 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 9.8 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нэг их эмчид ногдох үзлэгийн тоо 1946.0 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өвчний учир амбулаторийн үзлэг 144513 буюу 37,2 хувиар өсч, идэвхитэй хяналт 9.3, гэрийн үзлэг 18.2, урьдчилан сэргийлэх үзлэг 76.9 хувиар тус тус өссөн байна.



5.2 Жирэмсний хяналт

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр 41295 эмэгтэйчүүд хамрагдсан ба 91,4 хувь нь эхний 3 сартайд, 7,9 хувь нь 4-

6 сартайд, 0.8 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад орсон байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 93,0 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 1,5 хувь нь цус багадалттай байна.

Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз болон заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 92.3 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 95,8 хувь, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 95,5 хувь нь хамрагдсан байна.



5.3 Үр хөндөлт

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар нийт 13 эмэгтэйчүүд үр хөндөх мэс ажилбарыг хийлгэсэн ба нийт үр хөндөлтийн 7 тохиолдол буюу 53,9 хувийг хожуу үр хөндөлт, 4 тохиолдол буюу 30,8 хувийг өсвөр насны үр хөндөлт эзэлж байна.

5.4 Халдварт бус өвчлөл

2024 оны эхний 9 сарын байдлаар халдварт бус өвчлөл 73282 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 37128 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 5332,4 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 1034 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1.4 хувийг эзэлж, 10000 хүн амд 75,5 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/


1. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 1412.0
2. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 984.5
3. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-819.9
4. Нүд ба түүний дайврын өвчин-446.9
5. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-446.5



5.5 Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 39023 (44,8%) хүн хамрагдсан бөгөөд 43,0

хувь нь эрэгтэй, 57,0 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 18,6 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна.

Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны нийт 29218 (54,3%) хүн хамрагдсанаас 42,0 хувь нь эрэгтэй, 58,0 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 9,0 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна.






5.6 Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 4801 (51,2%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 0,2 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй гарсан байна.

Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 26100 (61.2) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт (1.1%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг, үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.



5.7 Түргэн тусламжийн дуудлага

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 15041 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 14,6 хувь /2203/ нь алсын дуудлага, 2.5 хувь /371/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 55,7 дуудлага, АНЭ 16,3 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

5.8 Хэвтэн эмчлүүлэгсдийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 22373 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 149210 ор хоног ашигласан байна. Аймгийн дунджаар ор ашиглалтын хувь 68,5 дундаж ор хоног 6.7 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 285 хүнээр, ор хоног 1635 тохиолдлоор тус тус өссөн байна.

6. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 147033 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 61.9 хувь
- Өвчний учир үзлэг 11.9 хувь
- Диспансерийн хяналт 6.9 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 18.9 хувь
- Гэрийн дуудлага 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 2854 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 9.7 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.6 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 453 жирэмсэн эмэгтэйдээс 87.9 хувийг эрт үед нь хяналтанд авч 93.8 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 189 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 35 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 59, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 4 тохиолдол эндсэн байна.

7. ХУВИЙН ЭМНЭЛГҮҮДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 27303 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 12.3 хувь
- Диспансерийн хяналт 3.3 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 0.01 хувь
- Гэрийн дуудлагаар 0.01 хувь
- Өвчний учир үзлэг 84.4 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 6328 хүн хэвтэн эмчлэгдэж, 45276 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.2 орны эргэлт 22.6 ба орны фонд ашиглалт 161.7, орны фонд ашиглалтын хувь 65.3 байна.

Нийт халдварт бус өвчний 1577 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 533 тохиолдол бүртгэгдсэн байна.

8. ХАЛДВАРТ ӨВЧИН

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 12 төрлийн 979 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 71,2 ногдож байна. Өмнөх оны мөн үеэс 17 тохиолдлоор буюу 10000 хүн амд ногдох өвчлөл 1,4-өөр буурсан байна.

10 000 хүн амд ногдох халдварт өвчнийг сумуудаар харьцуулбал: Баянзүрх (73,9), Тосонцэнгэл (97,0), Цэцэрлэг (89,4), Чандмань-Өндөр (88,6), Мөрөн (120,1) сумууд аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна.

8.1. Халдварт өвчний нас баралт

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар халдварт өвчний нас баралтын 2 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор өссөн байна.

10 000 хүн амд 71.2 байна. Нийт халдварт өвчний нас баралтын 2 тохиолдол нь сүрьеэгийн нас баралт байна.

8.2. Цочмог халдварт өвчин

Нийт цочмог халдварт өвчний 532 тохиолдлоос:

- Сальмонеллэз 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хоолны хордлого 8 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 48 тохиолдлоор
- Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Хепатит В 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Хепатит С 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Ёлом 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор
- Хачигт энцефалит 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Сүрьеэ 35 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 23 тохиолдлоор
- Улаан-Эсэргэнэ 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Ковид-19 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 46 тохиолдлоор тус тус буурч
- Цусан суулга 68 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 18 тохиолдлоор
- Салхинцэцэг 385 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 277 тохиолдлоор
- Гахайн хавдар 4 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор тус тус өсч
- Гар хөл амны өвчин 20, Хачигт рикеттиоз 7 тохиолдол тус тус өмнөх оны мөн үетэй адил тохиолдол байна.
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.



8.3. Амьсгалын замын халдварт өвчин


2024 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд амьсгалын замын халдварт өвчний 444 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 45,4 хувийг эзэлж байна. Амьсгалын замын халдварт өвчин өмнөх оноос 254 тохиолдлоор өссөн байна.


8.4. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин

2024 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварт өвчний 447 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 45,7 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 148 тохиолдлоор буурсан байна.

Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 24.4 хувийг тэмбүү, 66.0 хувийг заг хүйтэн, 9.6 хувийг трихомониаз тус тус эзэлж байна.

- Тэмбүү 109 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор
- Трихомониаз 43 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор тус тус өсч
- Гонококкт халдвар 295 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 158 тохиолдлоор буурсан байна.






9.ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

2024 оны эхний 9 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 532 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс цэврүүт тууралт 72.2 хувь (384), цочмог халууралт тууралтат 10.7 хувь (57), цочмог цусархаг тууралтат 14.3 хувь (76), цочмог усархаг 0.6 хувь (3), цочмог шарлалттай 0.6 хувь (3), гахай хавдар 0.6 хувь (3), хоолны хордлогот халдвар 0.9 хувь (5) тус тус бүртгэгдсэн байна.

Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/







Тохиолдлын нэр	2023 он		2024 он	
	бодит тоо	дүнд эзлэх хувь	бодит тоо	дүнд эзлэх хувь
Халууралт тууралт	63	21.4	57	10.7
Цэврүүт тууралт	121	41.2	384	72.2
Цусархаг суулгалт	42	14.3	76	14.3
Усархаг суулгалт	6	2.0	3	0.6
Цочмог шарлалт	6	2.0	3	0.6
Гахайн хавдар	0	0.0	3	0.6
Боом	0	0.0	1	0.2
Хоолны хордлогот халдвар	56	19.0	5	0.9
Нийт	294	100.0	532	100.0



9. ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН

2024 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 27727 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 2025.6 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 20446 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1485.6 болсон байна.





ЗӨВЛӨМЖ: ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА М.ЭНХДАЛАЙ

Жирэмсний хяналт:

Жирэмсний эрт үеийн хяналт хангалтгүй байгаа нь ЭМС-ын 2024 оны 6-р сарын 24-ны А/292 тушаалыг хэрэгжүүлээгүй, эмч, мэргэжилтнүүд шинээр хэрэгжиж буй удирдамж, эмнэлзүйн зааврыг судлаагүй, стандартаас доогуур тусламж үйлчилгээ үзүүлж байна. Шилжилт хөдөлгөөн болон эрүүл мэндийн боловсрол мэдлэг дутмагаас шалтгаалан жирэмсний хяналтад огт ороогүй, эхийн хүндрэл гарах эрсдэл болж байна.

Амьгүй төрөлт:

Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг илрүүлэх асуумжийг бүрэн аваагүй, бэлгийн замын үрэвсэл, халдварын оношилгоо, эмчилгээ, эргэн хяналтыг хийгээгүй, жирэмсний хожуу хордлогын хүнд хэлбэртэй эхийг багийн эмчийн хяналтад шилжүүлсэн зэрэг нь амьгүй төрөлтөд хүргэсэн.

Эхийн өвчлөлийн байдлаар авч бүгд эрхтэн тогтолцооны эмгэгтэй, үүнд дотроо бөөр шээсний замын эмгэг, архаг артерийн даралт ихсэлт, хожуу хордлогын хүнд хэлбэрийн улмаас хэвийн байрласан ихэс цагаас өмнө ховхорч их эмжээний цус алдалтын улмаас ураг эх дотроо амьгүй болсон байна.

Гэрийн төрөлт:

Эх жирэмсний хяналтад хожуу орсон, хяналтын хугацаанд жирэмсэн үеийн мэдлэг олгох сургалтад хамрагдаагүй, төрөлт эхлэх шинж тэмдэг, хүлээгдэх хүндрэлийн талаар мэдлэг олгоогүйгээс эх гэртээ төрж, эрт үеийн цус алдалт, нярайн эндэгдэл хүндрэл гарсан байна.

Нярайн эндэгдэл:

Эндсэн газар АНЭ-т 12, Галт, Бүрэнтогтох, Арбулаг сумдад бүртгэгдсэн. Тээлтийн хугацаагаар дутуу төрөлт 5 тохиолдол (ураг орчмийн шингэний ихдэлт 3, ураг орчмийн шингэн цагаас эрт гарах 2), хугацаа гүйцсэн төрөлт 9, илүү тээлт 1 байна. Эхийн нас: 35-аас дээш насны 5 буюу 30%, үүнээс 44 настай эх дутуу төрөлт, ургийн гаж хөгжил оношлогдон нярайн амьсгал гачаалын улмаас эндсэн.

Эхийн эрүүл мэндийн хувьд 80% нь эрхтэн тогтолцооны эмгэг, жирэмсний хүндрэлтэй байсан.

№	Эхийн эмгэг буюу жирэмслэлт төрөлтийн хүндрэл	Тохиолдол	Эзлэх хувь
1	Бөөр шээсний замын эмгэг	4	28%
2	Цусны эрхтэн тогтолцооны эмгэг	3	2%
3	Эрт үеийн хордлого	5	33%
4	Хожуу хордлого хүнд хэлбэр	6	40%
5	Дутуу төрөхийг завдах	5	33%

Нярайн эндэгдлийн шалтгаанд төрөлхийн хөгжлийн гажиг 7 үүнд: зүрхний хүнд гажиг 4, Даун синдром, олон эрхтний гажиг, тархины усжилт тус бүр эзэлж байна.

Төрөлхийн хөгжлийн гажиг: бүх тоиолдол төрөх үед, төрсний дараах эхний 7 хоногтойд оношлогдсон байна. Гаж хөгжил оношлогдсон хүүхэдтэй эхчүүдийн 62% жирэмсэн үед фолийн хүчлийг огт хэрэглээгүй, 28% нь тогтмол бус хэрэглэсэн. Төрөлхийн хөгжлийн гажигтай 7 нярай эндсэн байна.

Хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр өгөх зөвлөмж:

1. Яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/294 дүгээр тушаал, 2018 оны А/545 дугаар тушаалын “Нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний заавар”-ын дагуу Эх, нярайн яаралтай тусламжийн цомгийг бэлэн байлгах
2. Эмч, эмнэлгийн ажилчдын яаралтай үед үзүүлэх бэлэн мэдлэг, чадварыг сайжруулах. Эх, нярай, хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж, амилуулах суурь тусламж, аюулгүй тээвэрлэлт дадлага сургалтыг үе шаттай тасралтгүй зохион байгуулж, үр дүнг үнэлдэг байх.

3. 0-5 насны хүүхдийн идэвхитэй хяналт, ЭМС-ын 2019 оны А/546 дугаар тушаал “Нэг хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийн журам”-ыг тусламж үйлчилгээнд хэрэгжүүлэх (1 сар хүртэл 4 удаа, 1-2 сартайд сард 2 удаа, 3-12 сар хүртэл сар бүр).
4. Эх, нярайн хүндрэл бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагууд Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/112 дугаар тушаалыг хэрэгжүүлэх, дээрх тохиолдлыг eburtgel.hdc.gov.mn цахим санд бүртгэх, хариу арга хэмжээг зохион байгуулах.
5. 0-59 сартай хүүхэдтэй эцэг эх асран хамгаалагч нарт өгөх сургалт сурталчилгааны ажлыг чанаржуулах хамралтыг нэмэгдүүлэх, үр дүнг тооцох, бага насны хүүхдэд зонхилон тохиолдох өвчний үед илрэх аюултай шинж тэмдгийг таних, эмнэлгийн тусламж хайх талаарх зөв мэдлэгийг эцэг эх, асран хамгаалагч нарт тасралтгүй олгох.
6. Хүүхдийн иж бүрэн цогц үзлэгийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаалын хавсралтанд заасан маятын дагуу 9 сар, 18 сар, 36 сар, 48 сар, 60 сартай хийж, цахимд шивж дүгнэлтийг эцэг эх асран хамгаалагч нарт гарган өгч, илэрсэн өвчлөл, өсөлтийн хоцрогдлыг хяналтанд авч диспансерын хяналтын картыг хөтлөн эрүүлжүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.
7. Эмч, сувилагч нарыг эмнэлзүйн талаар батлагдсан тушаал, заавар, удирдамж, стандарт, аргазүйгээр хангаж ажил үйлчилгээндээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх.
8. Эрүүл мэндийн чанар, аюулгүй байдлын баг, сувилахуйн баг анхан шатны маягт (Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, өвчний түүх, сувилахуйн түүх, жирэмсний хөтөч, диспансерын хяналтын карт, хүүхдийн өвчний цогц менежмент, олон нийтэд түшиглэсэн хүүхдийн өвчний цогц менежмент г.м)-ын хөтлөлтөнд хуваарийн дагуу хяналт үнэлгээг хийж, үр дүнг тооцох
9. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх журмыг баримтлах, ялангуяа бага насны хүүхэд, жирэмсэн эх эмнэлэгт хандсан тохиолдолд харьяалал харгалзахгүй эмнэлгийн яаралтай тусламжийг хугацаа алдалгүй, шуурхай үзүүлэх, эмнэлэг хооронд чирэгдүүлэхгүй байх.
10. Ар гэр болон жирэмсэн эхэд жирэмсэн үед тохиолдох аюултай шинж тэмдэгийг мэддэг байх, нь хүндрэл үүсгэхгүй, цаг тухайд нь эрүүл мэндийн байгууллагад хандах боломжийг нэмэгдүүлэх талаар мэдээллийг өгөх.

Эхийн эрүүл мэнд, жирэмсний хяналтыг сайжруулах чиглэлээр

1. 2024 оны 6-р сарын А/292-р журам шинэчлэн батлах тухай жирэмсэн, төрсөн, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээ, хяналтын товллоор тасралтгүй тусламж үзүүлж хэвших. Дотоодын сургалтаар шинэчлэгдсэн тушаалуудыг цаг тухай бүр мэргэжилтэнүүдээ нэгдсэн мэдээллээр хангаж ажиллах. Жирэмсний хяналтанд орсон ээжүүдийг шинжилгээнд бүрэн хамруулж шинжилгээнд өөрчлөлт илэрсэн бол эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулсанаар жирэмсний хүндрэл эрсдэлээс урьдчилан сэргийлэх.
2. Жирэмсний хяналтын хугацаанд эрсдлийн үнэлгээг заасан хугацаанд бүрэн хийж хэвших, өмнөх төрөлтийн талаар мэдээллийг бүрэн авч эрсдлийг илрүүлэх, Өндөр эрсдэлтэй жирэмсэн эхийг эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад шилжүүлэх, мэдээллийг эрүүл мэндийн цахим системээр харилцан солилцох, хяналтын төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлж эргэх холбоотой ажиллах
3. Эх барих, хүүхдийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг ханган ажиллаж эхийн өвчлөл, хүндрэлийн үед мэргэжлийн эмч нараас зөвлөгөө авах, хүндрэлийн талаар Эрүүл мэндийн газарт мэдээлэл хүргүүлэх

4. Амьгүй болон дутуу төрөлтөөс сэргийлэх зорилгоор эхийн үрэвсэлт өвчнүүдийг эрт илрүүлж эмчилж хяналтад авах, эмчилгээний үр дүнг тухай бүр хянах шаардлагатай. Үүнд 2022 оны 2 сарын 10-ны А/77 бөөр шээсний замын халдварын оношлогоо эмчилгээний эмнэлзүйн заавар батлах тухай удирдамжыг мөрдөж бөөр шээсний замын үрэвсэл, бэлгийн замын үрэвсэлт өвчин, бэлгийн халдварт өвчнүүдийн илрүүлэг, эмчилж эрүүлжүүлж хяналтад авах
5. Ургийн гаж хөгжил нь нярайн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болсоор байгааг шат шатандаа анхаарч 10-12 долоо хоногтойд өндөр эрсдэлтэй жирэмсэн эх, 18-21 долоо хоногтойд ургийн гажиг илрүүлэх зорилгоор жирэмсэн эх бүрийг хоёрдугаар шатлалд шилжүүлэхийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд хэрэгжүүлж ажиллах, жирэмсэн эхчүүдэд фолийн хүчлийг тогтмол уулгаж хэвшүүлэх, олон найрлагат бичил тэжээлийн хэрэглээг нэмэгдүүлэх
6. Жирэмсэн эхийн шилжилт хөдөлгөөнийг ЭМТ-ийн дарга, эх баригч, эмч нар хамтарсан үзлэг хийж үзлэг шинжилгээ оношлогоог хийж онош тодруулах болон оношоо бататгаж гараас гарт шилжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, эхийг хүлээн авсан эрүүл мэндийн байгууллага анхны үзлэгийг хийж хүлээгдэх эрсдэл хүндрэлийг тооцох, багийн эмч нар хариуцсан нутаг дэвсгэрт өөр аймаг, сумаас ирсэн эх болон бага насны хүүхдийн мэдээлэлийг СЭМТ-ийн даргад тухай бүр мэдэгдэж байх
7. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, эмнэлэг хооронд өвчтөн шийлжүүлэх асуудлыг чирэгдэлгүй, аюулгүй, шуурхай зохион байгуулах, ялангуяа бага насны хүүхэд, эмнэлэгт хандсан тохиолдолд харьяалал харгалзахгүй эмнэлгийн яаралтай тусламжийг хугацаа алдалгүй, шуурхай үзүүлэх, эмнэлэг хооронд чирэгдүүлэхгүй байх. ЭМС-ын 2023 оны А/220 дугаар тушаал “Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам” шинээр батлагдсан хэрэгжүүлж ажиллах, Эрүүл мэндийн газрын даргын Журмын хэрэгжилтийг хангуулах тухай /2024 оны А/08 тушаалийг мөрдөж ажиллах
8. Багийн эмч, хороо хариуцсан эмч, мэргэжилтнүүдийн төрсний дараах 42 хоногийн эх нярайн гэрийн эргэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж гэрийн эргэлт хяналтыг сайжруулах, төрсний дараах эхэд болон бага насны хүүхдэд илрэх аюултай шинжийг эцэг эх асран хамгаалагч нарт зөвөлгөө өгөх, эмч мэргэжилтнүүдийн зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах
9. Эрүүл мэндийн байгууллагууд цус цусан бүтээгдэхүүний бэлэн байдлаа хангаж ЭМС-ын 2024 А/596 тоот тушаалыг хэрэгжүүлэх, сумын ЭМТ-үүд цусны сийвэнгийн хөөлдөгчид шаардлагатай цусны бэлдмэлийг татан авч нөөц бүрдүүлэх
10. Эхээс урагт халдах гурвалсан халдвараас сэргийлэх, БЗДХ, ДОХ/ХДХВ-с сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх журам 2ЭМС-ын 2023 оны А/133 хэрэгжүүлж ажиллах
11. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг үзүүлэх.
12. Алслагдсан нутагт амьдарч байгаа эсхүл өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдтэй эргэх холбоо тогтоон, төрөх хугацаанаас 07-14 хоногийн өмнө сэмт болон нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг авчирах.
13. Жирэмсэн эмэгтэй бүрийг эрт хяналтад хамруулахад иргэд, нийгмийн ажилтан, төрийн бус байгууллага, олон нийт, сайн дурын идэвхтний дэмжлэгийг авч, хамтран ажиллах
14. Нөхөн үржихүйн насны болон жирэмсэн эмэгтэй, түүний хамтрагч, гэр бүлийг оролцуулан бүлгийн сургалтыг 3-аас багагүй удаа цахим болон танхимаар эрүүл мэндийн байгууллагаас баталсан удирдамж, сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулах, Бүлгийн сургалт: Жирэмсний тээлтийн хугацаагаар ижил бүлгээр

хуваарилж эмэгтэй, түүний хамтрагч, гэр бүлийг оролцуулан эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг цахим болон танхимаар 3-аас доошгүй удаа зохион байгуулах.

ЗӨВЛӨМЖ: ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.ХАДБААТАР

Хөвсгөл аймагт 2024 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 84 эм хангамжийн байгууллага албан ёсны бүртгэлтэйгээс 74 эм хангамжийн байгууллага тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Эм хангамжийн байгууллагууд сар бүр Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалын дагуу сарын мэдээ тайланг сарын бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон Эрүүл мэндийн газарт тогтмол ирүүлж, мэдээ мэдээллийн үнэн бодит, тасралтгүй байдлыг ханган ажиллах ёстой.

2024 оны эхний 9 сарын байдлаар нийт эмийн сангуудаас 51 буюу 60,7хувь нь эм хангамжийн байгууллагын сарын мэдээг өгч ажилласан байна. Энэхүү мэдээлэлд Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй эм олгох гэрээт эмийн сангуудаас 25 эм хангамжийн байгууллага нь эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх жорын тоон мэдээллийг ирүүлсэн байна.

Цаашид: Эм хангамжийн байгууллагуудын сарын мэдээ тайланг цагалбарт хугацаанд үнэн бодитой ирүүлж, хамтран ажиллах.



Эрүүл мэндийн байгууллагуудын орлого, зарлагын нэгдсэн программ medee.1212.mn программ хангамжид мэдээллийг тогтмол оруулах.

ЗӨВЛӨМЖ: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР ЧИЙРЭГЖИЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.ХӨВСГӨЛ


ОСОЛ ГЭМТЛИЙН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТАД ХИЙСЭН ДҮГНЭЛТ БОЛОН ЗӨВЛӨМЖ

Нэг. Өвчлөл

2024 оны эхний 9 сарын байдлаар Осол гэмтлийн өвчлөл 955 тохиолдол 10000 хүн амд 75.5 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 168 тохиолдлоор буюу 12.5%-аар буурсан үзүүлэлттэй байна. Тэргүүлэх шалтгааныг авч үзвэл


- 
- Бүх төрлийн уналт-284, өмнөх оноос 69 тохиолдлоор,
 - Зам тээврийн осол-250, өмнөх оноос 46 тохиолдлоор,
 - Хүчирхийлэл-116, өмнөх оноос 27 тохиолдлоор,
 - Амьгүй механик хүчин зүйлд өртөх- 169,
 - өмнөх оноос 7 тохиолдлоор,
 - Түлэгдэлт-32 өмнөх оноос 24 тохиолдлоор тус тус буурсан бол
 - Амьтай механик хүчинд өртөх-71 өмнөх оноос 8 тохиолдлоор,
 - Санамсаргүй хордох, хорт бодист өртөх-18 өмнөх оноос 8 тохиолдлоор тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- 

Осол гэмтлийн өвчлөл сумдаар




2024 он гарсаар Галт, Жаргалант, Тариалан, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Ханх, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Хатгал, Цагааннуур сумуудад 20-оос дээш өвчлөл бүртгэгдсэн ба өмнөх жилүүдтэй харьцуулахад буурахгүй байна.


Тэргүүлэх шалтгаан



Зам тээврийн осол гэмтлийн өвчлөл




Зам тээврийн осол гэмтлийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанаар авч үзвэл Мотоциклтой зам тээврийн осолд орох 123, Суудлын автомашинтай осолд орох 65, Морь малаас унаж осолд орох 61, явганаас машинд мөргүүлж осолд орох 16 бүртгэгдэж эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авсан байна.



Хоёр. Нас баралт

2024 оны эхний 9 сарын байдлаар осол гэмтлийн нас баралт 97 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 7.7 буюу өмнөх оны мөн үеэс 31 тохиолдол буюу 42.6%-аар өссөн үзүүлэлттэй байна. Тэргүүлэх шалтгаанаар авч үзвэл

- Амиа хорлолт 36 тохиолдол өмнөх оноос 15 тохиолдол /71%/-аар өссөн,
- Хордож нас барсан 18 тохиолдол өмнөх оноос 2 тохиолдлоор өссөн,
- Зам тээвэр нас баралт 15 тохиолдол өмнөх оноос 4 тохиолдлоор өссөн,
- Усан живэх 5 тохиолдол өмнөх оноос 3 тохиолдлоор буурсан,
- Байгалийн хүчин зүйлд өртөж 4 тохиолдол өмнөх оноос 1 тохиолдлоор өссөн
- Хүчирхийллийн улмаас 7 тохиолдол өмнөх оноос 3 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.






Мөн 2023 оны 9 сарын байдлаар 0-1 нас хүүхдийн нас баралт Хатгал суманд 1 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2024 онд Галт 2, Ханх 1, Гурван гал өрхийн эрүүл мэндийн төвд 1 тохиолдол бүртгэгдсэн, 1-5 насны хүүхдийн нас баралт 2023 онд Төмөрбулаг 2, Хатгал 1, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 1 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2024 онд Бүрэнтогтох 1, Тариалан 1, Хатгал сумын эрүүл мэндийн төвд 1 тохиолдол тус тус бүртгэгдээд байна.




2024 оны 9 сарын байдлаар Арбулаг, Шинэ-Идэр суманд осол гэмтлийн нас баралт бүртгэгдээгүй бол Баянзүрх-4, Бүрэнтогтох-5, Ренчинлхүмбэ-3, Тариалан-7, Тосонцэнгэл-6, Түнэл-6, Ханх-7, Цагаан-Уул-3, Цагаан-Үүр-3, Цэцэрлэг-2, Чандмань-Өндөр-33, Хатгал-6, Галт суманд 9 нас баралт буюу хамгийн их бүртгэгдсэн, Далайн-Элбэрэлт-7, Энэрэл-5, Энх-Үйлс-2, Гурвангал-3 нас баралт, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 6 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.




Амиа хорлох нас баралтын тохиолдол ихэнх сумдад жил бүр давтагдан гарсаар байгаа ба Галт-5, Ренчинлхүмбэ-2, Түнэл-5, Ханх-5 Хатгал-3, Далайн-Элбэрэлт 5, Энэрэл-3 тохиолдол 2024 оны 9 сарын байдлаар бүртгэгдсэн байна.






Зам тээврийн ослын улмаас 15 иргэн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор буурсан.



2024 он гарсаар санамсаргүй хордох, хорт бодист өртөж нас барах 18 тохиолдол бүртгэгдсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2 тохиолдлоор өссөн байна. Мөн эдгээр нас баралт нь бүгд архины хордлого байна.



Осол гэмтлийн 97 нас баралтын 34 буюу 35%, 1034 өвчлөлийн 196 буюу 18.9% нь согтууруулах ундаа хэрэглэсэн байсан ба өвчлөл өмнөх оноос буурсан боловч согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осолд өртөж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байгаа иргэдийн тоо жил ирэх тусам нэмэгдэх төлөвтэй байна.

Гурав. Зөвлөмж

2024 оны эхний 9 сарын байдлаар Осол гэмтлийн өвчлөл нас баралт өмнөх оны мөн үеийнхээс бүх тохиолдолд өссөн, 0-5 нас хүүхдийн нас баралт өссөн, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлсэн, хүйтний улирал эхэлж байгаатай холбоотойгоор болзошгүй осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Осол гэмтлийн нас баралтын 2-оос дээш тохиолдол гарсан сумууд нас баралтын шалтгаан нөхцөлийг тодорхойлж салбар дундын хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулж цаашид анхаарах асуудал, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх

2. Амиа хорлолтын нас баралт бүртгэгдсэн Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Галт, Жаргалант, Рашаант, Ренчинлхүмбэ, Тариалан, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Түнэл, Улаан-Уул, Ханх, Хатгал, Цагаан-Уул, Цагааннуур, Эрдэнэбулган сумд, Далайн-Элбэрэлт, Дэлгэрмөрөн, Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвүүд нас баралт бүрийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж дүгнэлт хийж, салбар байгууллагуудтай хамтран ажиллах, мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө мэдээллийг авч хэрэгжүүлж ажиллах

3. Нийт нас баралтад согтууруулах ундааны хэрэглээ их байгаа ба санамсаргүй хордох, хорт бодист өртөж нас барах тохиолдлууд буурахгүй байна. Иймд иргэдэд согтууруулах ундааны хор хөнөөл, учирч болох эрсдэлийн чиглэлээр салбар байгууллагуудтай хамтран сургалт сурталчилгааг эрчимжүүлэх

4. Нийт нутгаар цас орж хүйтний улирал эхэлж байгаатай холбоотойгоор өндөр даваа, том жижиг гол мөрөн хөлдөж халтиргаа гулгаа үүсэж эхлэх тул баталгаат зам, гарам, гүүрээр анхаарал болгоомжтой зорчин болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг эрчимжүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах

5. Нийт осол гэмтлийн өвчлөл, нас баралтад 0-19 насны хүүхдийн эзлэх хувь өндөр байгаа тул бага насны хүүхэдтэй өрх бүрд чиглэсэн гарч болзошгүй осол гэмтлээс сэргийлэх мэдээ мэдээллийг бэлтгэж хүргэх ажлыг эрчимжүүлэх, өсвөр насны хүүхэд залуучуудад Ерөнхий боловсролын сургуультай хамтран сургалт, мэдээ мэдээллийг өгч ажиллах

6. Бага насны хүүхдийн осол гэмтлийн нас баралт буурахгүй байгаа тул хүүхдийг хараа хяналтгүй үлдээхгүй байх, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор хүүхдийг автомашинаар тээвэрлэхдээ зориулалтын суудалд суулгаж тээвэрлэх, хамгаалалтын бүсийг тогтмол зүүлгэх, замын хөдөлгөөн оролцохдоо гарцаар гарах дадалд сургах талаар эцэг эх, асран хамгаалагч нар ухуулга нөлөөллийн арга хэмжээг авч ажиллах

7. Тухайн орон нутагт осол гэмтлийн тохиолдлууд их гардаг хар цэгүүдийг тодорхойлж дүн шинжилгээ хийж тухайн цэгүүдэд сэрэмжлүүлэг самбарыг байршуулж иргэдийг осол гэмтэлд өртөхөөс сэргийлж ажиллах

8. Нийт осол гэмтлийн нас баралтын 15.4%, өвчлөлийн 27.3%-ийг зам тээвэр, авто машинтай холбоотой байгаа тул салбар байгууллагуудтай хамтран үзлэг шалгалтыг явуулж, урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулах, зам тээврийн өвчлөлийн 43.4%-ийг мотоциклтой холбоотой осол гэмтэл эзэлж байгаа тул өсвөр насны хүүхдийн мотоциклын хэрэглээ, мотоциклын бүтэн байдал, өвлийн

улиралд хэрэглэхгүй байх зэрэгт цагдаагын байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг 12 дугаар сарын 5-ний дотор эрүүл мэндийн газрын Биеийн тамир чийрэгжилт, Осол гэмтлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Хөвсгөлд khuvsqul@khs.moh.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

ЗӨВЛӨМЖ: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТАРХВАР СУДЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.ӨЛЗИЙСАЙХАН

Халдварт өвчний хам шинжээр 532 тохиолдлыг бүртгэж мэдээлснээс 89,6 хувь нь халдварт өвчний онош батлагдсан .

Нийт халдварт өвчний 10,000 хүн ам дахь тохиолдлын тоогоор аймгийн дунджаас өвчлөл өндөр 4 сум байна. Үүнд:Тариалан 289,9, Тосонцэнгэл 270,1, Цэцэрлэг 313,2, Мөрөн 417,7 тохиолдол бүртгэгдсэн байна.

Нийт өвчлөлийн 52,6% нь Мөрөн суманд бүртгэгдсэн .

Салхинцэцэг, цусан суулга тус тус нэмэгдэж, гахайн хавдар 4 тохиолдол бүртгэгдсэн байна. Салхинцэцэг нийт өвчлөлийн дотор 75,1%, нийт амьсгалын замын тууралтат халдварын дотор 87 %-ийг эзэлж, бусад халдваруудтай харьцуулахад өндөр бүртгэгдсэн.

Томуу томуу төст өвчин 40 долоо хоногийн хугацаанд аймгийн хэмжээнд 10 000 хүн амд дунджаар 2025,6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 540 тохиолдолоор их байна. Аймгийн хэмжээнд 37 дугаар долоо хоногоос эхлэн өвчлөл нэмэгдэж 10 000 хүн амд 25,2 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх томуугийн улиралын мөн үетэй харьцуулахад 21,2 тохиолдолоор их байна.

Зөвлөмж

1. Халдварт өвчний хам шинж сэжигтэй өвөрмөц тохиолдлын бүртгэл мэдээллийг сайжруулж, ЭМС-ын 2018 оны А/527 дугаар тушаалыг мөрдөж, тохиолдлын тодорхойлолтын дагуу хам шинжээр бүртгэх , дэгдэлтийг босго үзүүлэлтийн дагуу яаралтай мэдээлж анхны арга хэмжээг авч ажиллах.
2. Гахайн хавдар зэрэг тарилгатай халдварт өвчин бүртгэгдсэн тохиолдолд тандалт судалгааг хийж, эрүүл мэндийн газарт мэдээлэх
3. Амьсгалын замын халдварын үед нийгмийн эрүүл мэнд, олон нийтэд чиглэсэн арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлэх.
4. Нэмэлт амбулаторийг өвчлөлийн түвшин, нөхцөл байдалтай уялдуулан нэмэлтээр зохион байгуулах, төлөвлөх
5. Эрүүл мэндийн байгууллагууд давтан хэвтэлтэнд хяналт тавих, халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг эрчимжүүлэх.

Цусан суулга, салхин цэцэг, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сургалт, сурталчилгаа, санамж, зөвлөгөө мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, эрчимжүүлэх

ЗӨВЛӨМЖ: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.БАДАМТУНГАЛАГ

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

2024 оны 3 дугаар улирлын байдлаар 0-59 сартай давхардсан тоогоор нийт 42091 хүүхэд өсөлтийн хяналтад хамрагдсан ба өсөлтийн хяналт 90%-тай байна. Өсөлтийн хяналтад хамрагдсан хүүхдүүдээс өсөлтийн хоцрогдолтой 37 хүүхэд /0.08%/, туранхай 9 /0.02%/, тураалтай 23 /0.1%/ хүүхэд бүртгэгдсэн нь өмнөх оны үзүүлэлтээс өсөлтийн хоцрогдол 21 хүүхдээр, туранхай 14 хүүхдээр, тураал 13 хүүхдээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Харьяаллаар нь авч үзвэл туранхай хүүхэд Цагаан-Үүр суманд 2, тураалтай хүүхэд Бүрэнтогтох суманд 7, Далай-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төвд 4, Тариалан, Түнэл сумдад 3, өсөлтийн хоцрогдолтой хүүхэд Далай-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төвд 19, Хатгал суманд 5, Рашаант, Цагааннуур суманд тус тус 3 буюу хамгийн олон тохиолдож байна.

Мөн эхний 9 сарын байдлаар өсөлтийн хяналтад хамрагдсан хүүхдүүдээс А амин дэм уусан 06-59 сартай 10273 хүүхэд буюу 90.5% нь, Д амин дэм уусан 0-59 сартай 24507 хүүхэд буюу 60% нь, ОНБТБ уусан 06-23 сартай 3141 хүүхэд буюу 9.2% нь тус тус амин дэм, бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн байна. 2023 оны III улиралтай харьцуулахад А амин дэмийн хамралт 3.5%-иар, Д амин дэмийн хамралт 11%-иар өссөн бол ОНБТБ хэрэглэсэн хүүхдийн тоо 1.6%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Цаашид анхаарах зөвлөмж:

1. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 490 дүгээр тушаалын дагуу амин дэм, бичил тэжээлийн бэлдмэлийн нөөцийг бүрдүүлж, хэрэглээг нэмэгдүүлэн ажиллах, хэрэглээг дэмжих зорилгоор ОНБТБ, А, Д амин дэмийн ач тус, хэрэглэх хэмжээ, хугацааны талаар мэдээлэл, сургалт зөвлөгөөг эцэг эхэд тасралтгүй өгч ажиллах.
2. ОНБТБ-ийн орлого, зарлага, хэрэглээг ОНБТБ-ийн хагас жилийн мэдээтэй тулгаж, үлдэгдлийг шахаж, хамралтын хувийг нэмэгдүүлж ажиллах.
3. Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 509 дүгээр албан бичгээр хүргэгдсэн бага насны хүүхдийг чийрэгжүүлэх зуны сувиллын тайлан ирүүлэлтийн хувь 80%-тай байгаа ба Дэлгэрмөрөн өрхийн эрүүл мэндийн төв, Тариалан, Төмөрбулаг, Түнэл, Цагаан-уул, Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төвүүд 10 сард багтааж ирүүлэх.
4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 0-5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтыг товлолын дагуу сар бүр хийж, хооллолтын бэрхшээлийг эрт үед нь илрүүлж, насанд тохирсон хооллолтын зөвлөгөө үйлчилгээг чанартай хүргэж, бэрхшээлийг арилгах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.
5. Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт сар бүрийн үзлэгийн тэмдэглэл болон өсөлт хөгжлийн муруйг тэмдэглэх, хэрхэн тэмдэглэх талаар эцэг эхэд зааж сургах.
6. Нялх бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх сургалтад хамрагдсан эмч, сувилагч нар дотоодын сургалтаар эрүүл мэндийн төвийн ажилчдад сургалт хийж тайлангаа 11 сарын 01-ны дотор ирүүлэх

- А амин дэмийн уулт 10-11 сар дуустал үргэлжлэх тул хамралтын хувийг нэмэгдүүлж ажиллах, Өрхийн эрүүл мэндийн төвүүд 6-59 сартай хүүхдүүдийн А амин дэмийн уултын давхардалт үүсгэхгүйн тулд цэцэрлэгээр бус харьяа өрхөөр уулгахад анхаарах

ЗӨВЛӨМЖ: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.ЧАГЦАЛНЯМ

Сорьц тээвэрлэлт: 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 144 удаагийн давтамжтай 249 сэжигтэй тохиолдлын цэрний сорьц тээвэрлэлт хийсэн байна. Аймгийн хэмжээнд сорьц тээвэрлэлт дундаж 26.1% буюу хангалтгүй байна.

Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв 2024 оны 3 дугаар улирлын байдлаар огт сорьц тээвэрлэлт хийгээгүй байна.



Зөвлөмж:

1. Сүрьеэ:

- Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт аймгийн дунджаас бага байгаа нэгжүүд сургалт сурталчилгааг ард иргэдэд хүргэж, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх
- Эрүүл мэндийн сайдын А/38 дугаар тушаалын дагуу Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын бүртгэлийн дэвтрийг эмч бүр хөтлөн, сэжигтэй тохиолдлоос цэрний шинжилгээнд хамруулж дараа дараагийн үйл ажиллагааг төлөвлөж, зохицуулалт хийж ажиллах
- Эрүүл мэндийн сайдын А/38 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу Эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг үнэн бодитой дэлгэрэнгүй гаргаж, эрсдэлт бүлгийн иргэдийг уг тушаалын дагуу үзлэг, шинжилгээнд давтамжийн дагуу хамруулах
- Сорьц тээвэрлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, сард 2 удаагийн 4 хүний сорьцыг тогтмол тээвэрлэж хэвших

2. БЗДХ:

1. 16-65 насны БЗДХ-ийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт аймгийн дунджаас бага байгаа нэгжүүд сургалт сурталчилгааг ард иргэдэд хүргэж, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх
2. Илэрсэн тэмбүү өвчнийг бүрэн эрүүлжүүлэх, тэдгээрийн хавьтал судлах ажлын чанарыг сайжруулах
3. Жирэмсэн эмэгтэйчүүдийг үзлэг шинжилгээнд товллын дагуу бүрэн хамруулах
4. Иргэдэд чиглэсэн нэр хаяггүй, нууцлал хадгалсан зөвлөгөө үйлчилгээг бий болгох
5. Түр оршин суугч, явуулын ажил хийдэг, зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх идэвхтэй илрүүлэг үзлэг зохион байгуулах

3. Дархлаажуулалт:

1. 0-15 настай хүүхдэд заавал хийх дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр сар бүр нөхөн дархлаажуулах ажлыг зохион байгуулах.
2. Вакцин био бэлдмэлийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу зохих хэмд хадгалж, вакцины хүйтэн хэлхээний горимд тогтмол хяналт хийн, хэм хяналтын дэвтэрт өглөө орой бүр тэмдэглэл хөтлөх, нэмэлт цахилгааны эх үүсгэврийн бэлэн байдлыг хангах.
3. Тайлан мэдээг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалж мэдээг цаг тухайд ирүүлэх.

ЗӨВЛӨМЖ: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.ГЭРЭЛТУЯА

Аймгийн хэмжээнд 2024 оны 3-р улирлын байдлаар Зонхилон тохиолдох халдварт бус өвчний 5 төрлийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын дундаж 51,9% байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.16%-аар өссөн байна. Тухайлбал:

- Артерийн даралт ихсэх өвчний илрүүлэг 44.8%,
- чихрийн шижин хэв шинж 2 өвчний илрүүлэг 54.3%,
- элэгний өмөнгийн илрүүлэг 48.3%,
- умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг 51.2%,
- хөхний өмөнгийн илрүүлэг 61.2%-ийн явцтай байна.


Эрт илрүүлгийн хамрагдалтыг 5 үзлэгийн дунджаар нэгтгэн дүгнэж үзэхэд 70% буюу түүнээс дээш хувиар зорилтот түвшинг хангаж ажилласан 6 СЭМТөв байгаа нь нийт анхан шатны ЭМБ-уудын 21.4%-ийг эзэлж байна. Зорилтот хүн амыг 50% буюу түүнээс доош хувиар хамруулсан 16 сум, өрхийн ЭМТөвүүд байгаа нь нийт анхан шатны ЭМБ-ын 57%-ийг эзэлж байгаа бөгөөд цаашид үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг зөвлөж байна.

Үзлэгийг төрлөөр зорилтот түвшинд хүрээгүй байгаа буюу цаашид онцгой анхаарч ажиллах шаардлагатай ЭМБ-ууд:

1. Артерийн гипертензи эрт илрүүлэг: Арбулаг, Баянзүрх, Галт, Тосонцэнгэл, Түнэл, Шинэ-Идэр, Эрдэнэбулган, Рашаант, Тариалан, Ханх, Цагаан-Уул, Чандмань-Өндөр зэрэг СЭМТөвүүд

2. Чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг: Арбулаг, Рашаант, Тосонцэнгэл, Тариалан, Шинэ-Идэр, Ханх, Цагаан-Уул, Чандмань-Өндөр, Цагааннуур зэрэг СЭМТөвүүд
3. Элэгний өмөнгийн эрт илрүүлэг үзлэг: Арбулаг, Галт, Ханх, Чандмань-Өндөр, Жаргалант, Цагаан-Уул, Шинэ-Идэр, Эрдэнэбулган СЭМТөвүүд, Гурван гал, Энх-Үйлс ӨЭМТөвүүд
4. Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг: Жаргалант, Цагаан-Уул, Шинэ-Идэр, Эрдэнэбулган, Арбулаг, Галт, Ханх, Чандмань-Өндөр СЭМТөвүүд, Гурван гал, Энх-Үйлс ӨЭМТөвүүд
5. Хөхний өмөнгийн эрт илрүүлэг: Төмөрбулаг, Ханх, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Цагааннуур зэрэг СЭМТөвүүд, Дэлгэрмөрөн ӨЭМТөв

Эрт илрүүлгээр үр дүнгээр диспансерийн хяналтанд авсан хүний тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан графикаар харуулбал:



Зөвлөмж:

1. Аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар эрт илрүүлэг үзлэгийн дундаж хамралтыг 70%-д хүргэх зорилт тавин ажиллаж байгаа тул эрүүл мэндийн байгууллагууд үлдсэн 2 сарын хугацаанд төлөвлөгөө гарган эрт илрүүлэг, үзлэгийг эрчимжүүлж ажиллах.

2. Эрт илрүүлэг үзлэг нь аймгийн дунджаас доогуур байгаа буюу үзлэгийн дунджаар 50%-с доош, үзлэгийн төрлөөр 30%-с доош буюу маш хангалтгүй байгаа эрүүл мэндийн байгууллагууд онцгойлон анхаарч үйл ажиллагааг эрчимжүүлэн үзлэгийн хамрагдалтыг 70%-д хүргэж нэмэгдүүлэх.

3. Эрт илрүүлэг үзлэгийг программд шивэх ажлыг тухай бүр хийж хэвших ба эрт илрүүлэг үзлэгийн чанар, илрүүлэлтэд анхаарч ажиллах.

4. Эрт илрүүлэг үзлэг зохион байгуулахад нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн бэлтгэл ажлыг ханган ажиллах хэвших.

5. Иргэдэд ХБӨ-ний эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдлыг ойлгуулах МСС-г хийж тасралтгүй хийж, зорилтот насны хүн амыг бүрэн хамруулахыг зөвлөж байна.

6. Эрт илрүүлгийн үзлэгээр өвчтэй илэрсэн иргэдийг диспансерын хяналтанд авч эмчлэн эрүүлжүүлэх

ХЯНАСАН:

ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
М.ҮҮРИЙНБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА